

ЭМГ-ЫН 10 ДУГААР 7 ХОНОГИЙН МЭДЭЭ

Нэг. Зарим статистик үзүүлэлт

Нийт төрөлт - 54
Амьд төрөлт - 54
Амьгүй төрөлт - 0
Дутуу төрөлт - 2
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл - 1
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл - 0
Эхийн ноцтой хүндрэл - 0
Төрөлхийн гажиг - 1
Гэрийн төрөлт - 0

Хоёр. Томуу, томуу төст өвчин

Аймгийн хэмжээнд амбулаторид суурилсан томуугийн харуулдан тандалтын 18 нэгжүүдэд 10 дугаар долоо хоногт нийт 4457 хүн үйлчлүүлсний 362 буюу 8.1% нь ТТӨ-тэй тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх 7 хоногтой харьцуулахад 1.4%-иар нэмэгдсэн үзүүлэлтэй байна.

Амьсгалын замын цочмог хүнд халдварын шалтгаантай эмнэлэгт хэвтэгсэд нийт хэвтэгсэдийн 22.9%-ийг эзэлж, өмнөх долоо хоногтой харьцуулахад 0.1%-иар буурсан үзүүлэлтэй байна.

Түргэн тусламжийн 484 дуудлагын 168 буюу 34.7%-ийг ТТӨ-ий шалтгаантай дуудлага эзэлж байна. Өмнөх долоо хоногтой харьцуулахад 2.2%-иар нэмэгдсэн үзүүлэлтэй байна.

Гурав. Нийгмийн эрүүл мэнд

Эрүүл мэндийн газар Нэгдсэн эмнэлэгтэй хамтран бөөр хамгаалах дэлхийн өдрийг “Эрүүл бөөр хаана, хэнд ч” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж, 50 гаруй ард иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, бөөрний эмгэгийн үед хийх дасгал хөдөлгөөн зааж, уг эмгэгээс сэргийлэх чиглэлээр сургалт хийж гарын авлага тараасан.

Дервес ТВ-д “Хорт хавдраас сэргийлэх” чиглэлээр ард иргэдэд чиглэсэн мэдээлэл өгсөн.

Аймгийн Прокурорын байгууллагын ажилчдын бие бялдрын түвшин тогтоох сорил авч, биеийн жингийн индекс ба биеийн найрлага тодорхойлох аппаратаар ажилчдыг өөх тос, уураг, булчин, ус, давсны хэмжээг тодорхойлж бодисын солилцооны идэвхжилт буюу биологийн насыг тодорхойлж арга зүйн зөвлөгөө өгөв.

Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор ЭМЯ-нд 40.0 сая төгрөгний үнэтэй хог хаягдлыг халдваргүйжүүлэх автоклавын төслийг бичиж хүргүүлэв.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 21 албан хаагчдад бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ, сайн дурын зөвлөгөө шинжилгээний кабинетийн талаар, бэлгэвч хэрэглэх заавар, урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдахын ач холбогдол, сүрьеэ өвчнөөс хэрхэн сэргийлэх чиглэлээр сургалтыг явуулж, ХДХВ/ДОХ, тэмбүү илрүүлэх хурдавчилсан шинжилгээнд хамруулав.

“Сүрьеэтэй тэмцэх өдөр”-ийг угтаж аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хоригдлуудыг сүрьеэгийн эмчийн үзлэгт хамруулж, сүрьеэ өвчний тухай ойлголт, мэдээлэл өгч ажилласан.

Дөрөв. Баяннуур сумын хүүхдүүдийн хоолны хордлогын шинжилгээний тухай

Хоолны хордлого оноштой нэр бүхий 11 хүүхэд 2019.02.25-ны 14.20 цагт ХӨСҮТ-д шулуун гэдэсний арчдасны нян өсгөвөрлөх шинжилгээ өгөхөд эмгэгтөрөгч нян илрээгүй байна.

Тав. Эмнэлгийн тусламж үйлчилгээ

Сум дундын эмнэлэг, сум өрхийн эмч, багийн 24 эмчийн Хүүхдийн Өвчний Цогц Менежментийн талаарх мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор 2019.03.12-16-ны өдрүүдэд буюу 5 хоногийн сургалтыг ЭМГ-аас санаачлан зохион байгуулж байна.

Сэтгэлд шингэсэн сувилахуйн тусламж, үйлчилгээ сэдэвт 2 багц цагийн сургалт зохион байгуулагдаж, 150 гаруй сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдав.

Уян зүү тавих чадварт сургах ажлын байрны чадавхижуулах сургалтанд 10 сувилагч хамрагдсан.

Монголын дотрын сувилагчдын нийгэмлэгээс Алтай сумын эрүүл мэндийн төвд сувилагчийн тэргэнцэр, пульоксиметр хандивлав.